

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/81/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatart@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. Аудитын тайлан	13
3.1 Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.3 Албан шаардлага.....	20
4.4 Зөвлөмж	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ДЭХГ	Дулаан эрчим хүчний газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/187
танай _____ -ны № _____ -т

ТӨВ АЙМГИЙН СҮМБЭР СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ДАВААСҮРЭН ТАНАА

Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний байгууллагаас цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар залруулагдаагүй 105,283.2 мянган төгрөгийн зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан, санхүүгийн тайланд өргөн тархсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D 2022/2022-01-АУДИТ БИЧИГ
19020571

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	68,585,967.82	70,919,221.33
33	АВЛАГА	0	98,255.51
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0	98,255.51
35	БАРАА МАТЕРИАЛ	68,585,967.82	70,820,965.82
35400	Хангамжийн материал	68,585,967.82	70,820,965.82
35410	Бичиг хэргийн материал	871,000.00	871,000.00
35420	Аж ахуйн материал	13,212,700.00	14,422,700.00
35430	Сэлбэг хэрэгсэл	329,000.00	329,000.00
35440	Түлш, шатах тослох материал	0.05	0.05
35470	Бусад хангамжийн материал	54,173,267.77	55,198,265.77
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	526,861,975.51	505,599,110.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	526,861,975.51	505,599,110.46
39200	Биет хөрөнгө	513,675,975.51	492,413,110.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	612,170,866.92	612,170,866.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	-132,233,514.09	-168,669,132.45
39203	Авто-тээврийн хэрэгсэл	84,718,314.00	92,718,314.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-75,343,314.17	-77,923,314.17
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	67,094,999.90	68,874,999.90
39206	Хуримтлагдсан элэгдэл	-61,741,308.85	-63,883,996.85
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	37,795,190.47	42,544,290.47
39208	Хуримтлагдсан элэгдэл	-30,774,544.24	-32,763,765.21
39209	Зам, гуурийн байгууламж	536,275,430.00	536,275,430.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-533,875,900.00	-534,675,743.32
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,598,944.45	19,598,944.45
39215	Хуримтлагдсан элэгдэл	-9,188.88	-1,853,783.28
39300	Биет бус хөрөнгө	13,186,000.00	13,186,000.00
39301	Програм хангамж	1,040,000.00	1,040,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,040,000.00	-1,040,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	13,186,000.00	13,186,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	595,447,943.33	576,518,331.79
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	1,248,255.51
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	1,248,255.51
41300	Өглөг	0	1,248,255.51
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	98,255.51
41360	Бусад өглөг	0	1,150,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0	1,150,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	595,447,943.33	575,270,076.28
51	Засгийн газрын хувь оролцоо	595,447,943.33	575,270,076.28
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн	365,678,073.22	365,678,073.22
51200	Хуримтлагдсан үр дүн	-18,662,205.35	-38,840,072.40
51210	Өмнөх үеийн үр дүн	-63,239,394.54	-18,662,205.35
51220	Тайлант үеийн үр дүн	44,577,189.19	-20,177,867.05
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	248,432,075.46	248,432,075.46
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	595,447,943.33	576,518,331.79

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	422,280,323.85	377,349,356.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,643,443.00	11,075,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	73,643,443.00	11,075,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	73,643,443.00	10,000,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	1,075,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	348,636,880.85	366,274,356.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,316,380.85	42,270,356.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0	26,009,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,316,380.85	5,664,430.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	10,596,926.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	329,320,500.00	324,004,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	329,320,500.00	324,004,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	377,703,134.66	396,452,223.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	377,703,134.66	396,452,223.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	343,121,716.56	374,072,339.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,385,856.39	202,309,151.30
210101	Үндсэн цалин	132,048,932.75	139,521,649.79
210102	Нэмэгдэл	27,047,137.96	30,315,460.46
210105	Гэрээт ажлын хөлс	32,289,785.68	32,472,041.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,966,998.51	26,128,427.09
210201	Тэтгэврийн даатгал	18,942,120.25	18,326,451.72
210202	Тэтгэмжийн даатгал	2,048,431.80	2,019,460.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,628,305.41	1,618,588.38
210204	Ажилгүйдлийн даатгал	394,876.43	374,529.59
210205	Эруул мэндийн даатгал	3,953,264.62	3,789,397.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,150,907.00	32,397,570.08
210301	Гэрэл, цахилгаан	9,074,290.50	4,129,542.08
210302	Түлш, халаалт	22,496,116.50	27,687,528.00
210303	Цэвэр, бохир ус	580,500.00	580,500.00

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	13,456,799.95	14,956,500.00
210401	Бичиг хэрэг	3,066,600.00	2,551,792.00
210402	Тээвэр, шатахуун	9,065,799.95	6,386,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,324,400.00	1,504,708.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	4,513,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	577,800.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	577,800.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,330,000.00	1,491,000.00
210702	Дотоод албан томилолт	2,330,000.00	1,491,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,203,709.00	2,615,806.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	27,473,389.00	1,365,806.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228,000.00	228,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	182,320.00	302,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,049,645.71	92,673,885.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,470,203.85	46,803,920.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	78,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,579,441.86	45,791,965.05
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,581,418.10	22,379,883.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,616,000.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,616,000.00	0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,965,418.10	22,379,883.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,965,418.10	22,379,883.53
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	44,577,189.19	-19,102,867.05
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0	1,075,000.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0	1,075,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	44,577,189.19	-20,177,867.05

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	365,678,073.22	248,432,075.46	-63,239,394.54	550,870,754.14
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	365,678,073.22	248,432,075.46	-63,239,394.54	550,870,754.14
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	44,577,189.19	44,577,189.19
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	365,678,073.22	248,432,075.46	-18,662,205.35	595,447,943.33
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	365,678,073.22	248,432,075.46	-18,662,205.35	595,447,943.33
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	365,678,073.22	248,432,075.46	-18,662,205.35	595,447,943.33
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-20,177,867.05	-20,177,867.05
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	365,678,073.22	248,432,075.46	-38,840,072.40	575,270,076.28

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	348,636,880.85	367,424,356.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	348,636,880.85	367,424,356.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,316,380.85	43,420,356.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0	26,009,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,316,380.85	16,261,356.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0	1,150,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	329,320,500.00	324,004,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	329,320,500.00	324,004,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	340,931,886.85	352,895,256.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	340,931,886.85	352,895,256.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,350,468.75	330,515,372.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,385,856.39	202,309,151.30
210101	Үндсэн цалин	132,048,932.75	139,521,649.79
210102	Нэмэгдэл	27,047,137.96	30,315,460.46
210105	Гэрээт ажлын хөлс	32,289,785.68	32,472,041.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,966,998.51	26,128,427.09
210201	Тэтгэврийн даатгал	18,942,120.25	18,326,451.72
210202	Тэтгэмжийн даатгал	2,048,431.80	2,019,460.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,628,305.41	1,618,588.38
210204	Ажилгүйдлийн даатгал	394,876.43	374,529.59
210205	Эрүүл мэндийн даатгал	3,953,264.62	3,789,397.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,150,907.00	32,397,570.08
210301	Гэрэл, цахилгаан	5,613,349.50	4,129,542.08
210302	Түлш, халаалт	25,957,057.50	27,687,528.00
210303	Цэвэр, бохир ус	580,500.00	580,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,015,700.00	14,956,500.00
210401	Бичиг хэрэг	3,071,500.00	2,551,792.00
210402	Тээвэр, шатахуун	7,547,200.00	5,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,397,000.00	1,504,708.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0	5,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,210,000.00	1,491,000.00
210702	Дотоод албан томилолт	2,210,000.00	1,491,000.00

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,763,303.00	1,917,926.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,032,983.00	667,926.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228,000.00	228,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	182,320.00	302,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,857,703.85	49,814,798.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,857,703.85	49,736,798.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0	78,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,581,418.10	22,379,883.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,616,000.00	0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	14,616,000.00	0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	19,965,418.10	22,379,883.53
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	19,965,418.10	22,379,883.53
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,704,994.00	14,529,100.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,705,000.00	14,529,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,705,000.00	14,529,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,705,000.00	14,529,100.00
223001	Бусад хөрөнгө	7,705,000.00	0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0	14,529,100.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-7,705,000.00	-14,529,100.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-6	0
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6	0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	325,675,500.00	305,683,248.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	325,675,500.00	305,683,248.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	325,675,500.00	305,683,248.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	204,328,100.00	202,309,151.30
210101	Үндсэн цалин	140,586,400.00	139,521,649.79
210102	Нэмэгдэл	31,113,400.00	30,315,460.46
210105	Гэрээт ажлын хөлс	32,628,300.00	32,472,041.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,584,200.00	26,128,427.09
210201	Тэтгэврийн даатгал	19,411,200.00	18,326,451.72
210202	Тэтгэмжийн даатгал	2,043,300.00	2,019,460.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,634,600.00	1,618,588.38
210204	Ажилгүйдлийн даатгал	408,500.00	374,529.59
210205	Эрүүл мэндийн даатгал	4,086,600.00	3,789,397.03
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,118,800.00	32,397,570.08
210301	Гэрэл, цахилгаан	6,500,000.00	4,129,542.08
210302	Түлш, халаалт	33,038,300.00	27,687,528.00
210303	Цэвэр, бохир ус	580,500.00	580,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,956,500.00	14,956,500.00
210401	Бичиг хэрэг	2,552,500.00	2,551,792.00
210402	Тээвэр, шатахуун	5,700,000.00	5,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,504,000.00	1,504,708.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,200,000.00	5,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,287,300.00	1,491,000.00
210702	Дотоод албан томилолт	5,287,300.00	1,491,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,547,500.00	1,547,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	297,500.00	297,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	320,000.00	320,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	400,000.00	400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228,000.00	228,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	302,000.00	302,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,353,100.00	25,353,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,353,100.00	25,353,100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	325,675,500.00	305,683,248.47
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	303,322,400.00	305,683,248.47
320001	Орон нутгийн төсвөөс	303,322,400.00	305,683,248.47
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	22,353,100.00	0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	22,353,100.00	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	39,361,224.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	39,361,224.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	39,361,224.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	370,426.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	370,426.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	38,990,798.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	38,912,798.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	78,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	39,361,224.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	39,361,224.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	39,361,224.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар нь Нийтийн үйлчилгээг хуулийн хүрээнд шуурхай хариуцлагатай хүргэж шууд ардчиллын зарчмыг баримталсан, мэдлэг чадварт суурилсан “Тунгалаг нутгийн захиргааны байгууллага” болох зорилго бүхий байгууллага юм.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын тушаалаар дотоод хяналт шалгалтын ажлын хэсэг 3 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулан батлагдсан төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Тус байгууллагад дотоод аудитын нэгж байхгүй байна.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 268,521.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,027.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3,222.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулга хийсэн тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 5,660.2 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 1,632.4 мянган төгрөгөөр өссөн байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 4,528.1 мянган төгрөгөөр тогтоогдсон байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд орон нутгийн төсвөөс 324,004.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 42,270.3 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 11,075.0 мянган төгрөг нийт 377,349.3 мянган төгрөг, өмнөх оноос 4,493.9 мянган төгрөгөөр буюу 10.6 хувиар буурсан байна. Энэ нь үнэ төлбөргүй орлого буурсантай холбоотой байна.

Зардал:

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 396,452.2 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 352,895.2 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 305,683.2 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100142355001 тоот дансанд 2021 онд 324,004.0 мянган төгрөгийн орлогын, 324,004.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100142355408 тоот дансанд 43,420.3 мянган төгрөгийн орлого төвлөрч, 43,420.3 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт /мян.төгрөг/
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		98.2	98.2
Урьдчилгаа			
Бараа материал	68,585.9	70,820.9	2,235.0
Үндсэн хөрөнгө	526,861.9	505,599.1	-21,262.8
Нийт хөрөнгө	595,447.9	576,518.3	-18,929.6
Өр төлбөр		1,248.2	1,248.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	595,447.9	575,270.0	-20,177.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	595,447.9	576,518.3	-18,929.6

Авлагын дансны үлдэгдэл 98.2 мянган төгрөг болж 98.2 мянган төгрөгөөр өссөн нь ХХОАТ-ын авлагатай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 70,820.9 мянган төгрөг болж 2,235.0 мянган төгрөгөөр өссөн нь бараа материал худалдан авалтаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 505,599.1 мянган төгрөг болж 21,262.8 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 14,529.1 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 10,000.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгө данснаас хасагдаагүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 575,270.0 мянган төгрөг болж 20,177.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сүмбэр сумын ЗДТГ-ын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 348,948.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 348,948.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 28,273.3 мянган төгрөгөөр бууруулж 320,675.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, эд хогшил, урсгал засварын зардал, томилолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг бууруулсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 325,675.5 мянган төгрөгийн төсвийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 324,004.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 305,683.2 мянган төгрөгийг зарцуулж, 18,320.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,018.9 мянган төгрөгийн хэмнэлттэй буюу 93.8 хувьтай байгаа нь албан хаагчид өөрчлөгдсөнөөс шалтгаалан цалин, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой зардал, дотоод албан томилолтын зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Засаг даргын Тамгын газраас шүлхий болон ковид цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 9,00.0 мянган төгрөг, Төв Чандмань ДЭХГ-аас Засгийн газраас төлсөн усны үнэ 4,844.4 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс сургалт болон мал тооллогын зардалд 448.4 мянган төгрөг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас хамтарсан багийн санхүүжилтэд 300.0 мянган төгрөг, Зуунмод сумын Засаг Даргын Тамгын газраас сургалтын унааны зардалд 201.5 мянган төгрөг, өвсний мөнгө 749.9 мянган төгрөг, цахим тендерийн хураамж 70.0 мянган төгрөг, Байгаль орчны нөхөн сэргээлтийн барьцаа 1,150.0 мянган төгрөг, цар тахалтай холбоотой иргэн, аж ахуйн нэгжээс өгсөн хандив 26,009.0 мянган төгрөг, нийт 42,773.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжид 370.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 38,912.8 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 78.0 мянган төгрөг, нийт 39,361.2 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдсэн 4,059.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга 2022 оны 1 дүгээр сард ажлаасаа чөлөөлөгдөж, одоогоор түр орлон гүйцэтгэж байна.

Тайлант онд ковид цар тахал болон зам, гүүрийн засварын ажилд зориулан 26,009.0 мянган төгрөгийн хандивыг иргэн, аж ахуйн нэгжээс авч зарцуулсан байна.

Нийт 5,664.9 мянган төгрөгийн цалинг Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр бус арилжааны банкаар дамжуулан олгосон байна.

3.8 Аудитын гол асуудал

Төв аймгийн Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар нь нийт 49,253.2 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, байгууллагын жижиг мөнгөн сангаар дамжуулан гаргасан 9,320.4 мянган төгрөгийн гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, бэлэн мөнгөний орлого, зарлагын баримт огт бичдэггүй, бэлтгэн нийлүүлэгчийн зарлагын падаан болон хүлээн авсан, хүлээлгэн өгсөн баримт хангалтгүй, мөнгөн урьдчилгааны тайлан гаргадаггүй, бараа материалын тайланг сар бүр нэр төрлөөр гаргадаггүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, бараа материалын тайланг шаардах хуудсанд нягтлан бодогч, төсөв захирагчаар гарын үсэг зуруулдаггүй, огт бөглөөгүй хоосон шаардах хуудаснууд хавсаргасан, шатахууны тооцоог боддоггүй, шатахууныг бөөн дүнгээр зарлагддаг, эд хөрөнгийн тооллогыг хийсэн боловч тооцоог бодоогүй, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цэсэнд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс хугацаандаа мэдээлсэн 130 мэдээлэл, хугацаа хоцроосон 18 мэдээлэл, мэдээлээгүй 1 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлангийн аудитад шаардлагатай баримт, материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар анхан шатны баримтын бүрдэл, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, журналуудын уялдаа, эд хөрөнгийн тооллоготой холбоотой 3 зөвлөмж өгөгдсөн байна. Хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдөр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нэмэлт санхүүжилтийн данс дахь орлогын талаар дараагийн аудитаар авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 211,438.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 106,154.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 690.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 104,593.2 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага бичив.

4.1 Залруулсан алдаа

Аймгийн Онцгой байдлын газраас ирсэн 1,075.0 мянган төгрөгийн хүнсний багцыг бүртгэж авалгүй зарлагадсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Төсвийн зарцуулаагүй үлдэгдэл болох 22,379.8 мянган төгрөгийг төвлөрүүлснийг буруу кодоор тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн

санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 14,529.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардлаар тайлагнаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Байгаль орчныг нөхөн сэргээх барьцаа сангийн орлогыг орлогоор хүлээн зөвшөөрсөн ба өглөг үүсгэлгүй тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Нэмэлт санхүүжилтийн орлого болох 43,420.3 мянган төгрөгийг эх үүсвэрээр нь тусад нь тайлагналгүй бөөн дүнгээр тайлагнасан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Байгууллагын жижиг мөнгөн сангаар дамжуулан гаргасан гүйлгээг кассаар дамжуулах бичилт хийдэггүй, харилцахаас шууд зардалд тайлагнадаг байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Урьдчилж төлсөн 14,280.0 мянган төгрөгийг зардлыг урьдчилгаа дансаар бүртгэлгүй өглөгийн дансанд бичсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай

хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Оны эцэст шатахууны картанд үлдэгдэл 690.0 мянган төгрөг байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 45 дугаар зүйлийн 45.2-т “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ”, 45.2.1-д “нэгжид ногдох норм, нормативаар тооцон төсвийг нь баталсан ба гүйцэтгэл нь анх тооцсон нэгжийн тоо хэмжээнээс бага бол”, санхүүгийн тайлангийн аудитын “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтын дагуу төлбөрийн акт тогтоов.

4.3 Албан шаардлага

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 49,253.2 мянган төгрөгөөр дутуу, 211.7 мянган төгрөгөөр илүү байна. Мөн ИТХ-ын шатахууны худалдан авалтын Э-баримтыг ЗДТГ-ын регистрийн дугаараар шивсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6-д “Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5-д Төлбөрийн баримт “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”, санхүүгийн тайлангийн аудитын “Иж бүрэн байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох

журам"-ын 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Байгууллагын жижиг мөнгөн сангаар дамжуулан гаргасан 9,320.4 мянган төгрөгийн гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, бэлэн мөнгөний орлого, зарлагын баримт огт бичдэггүй, , бэлтгэн нийлүүлэгчийн зарлагын падаан болон хүлээн авсан, хүлээлгэн өгсөн баримт хангалтгүй, мөнгөн урьдчилгааны тайлан гаргадаггүй байна. Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам”-ыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Бараа материалын тайланг сар бүр нэр төрөл, тоо хэмжээгээр гаргадаггүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, бараа материалын тайланг шаардах хуудсанд нягтлан бодогч, төсөв захирагчаар гарын үсэг зуруулдаггүй, огт бөглөөгүй хоосон шаардах хуудаснууд хавсаргасан байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 9-д “Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалгаж хүлээж авна” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Эд хөрөнгийн тооллогыг хийсэн боловч тооцоог бодоогүй, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гараагүй, шатахууны тооцоо бодоогүй, спидометрийн заалт дутуу бичдэг, шатахууныг бөөн дүнгээр зарлагаддаг байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн аудитын “Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.2-д “Хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа. зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Сүмбэр ЗДТГ	12	211,438.0	7	106,154.7	1	690.0	4	104,593.2		